

ТАНИЛЦУУЛГА

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн тухай

Нэг. Хуулийн төслийн зорилго, ач холбогдол

Монгол Улсын Их Хурлаас Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай бие даасан хуулийг 2004 онд батлан мөрдүүлж, улмаар 2013 онд шинэчлэн найруулсан байна.

Өнөөдрийн байдлаар манай улсад үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй нийт 64 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа¹ бөгөөд цаашид уул уурхайн салбарын хөгжлийг дагаж тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, импорт нэмэгдэхээр байна.

Гэвч тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр² тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хуулийн шаардлага тодорхой бус, Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрт нөлөө бүхий дүгнэлт гаргах эрхтэй “Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага”-ын болон шинжээчийн эрхийг хэн, хэрхэн олгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой заагаагүй зэрэг нь эрх зүйн хийдэлтэй байдал нь хуулийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэсэн байна.

Үүнээс гадна хүн амын дунд өргөн хэрэглээ болсон пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах зохицуулалтыг тодорхойлох, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулах дүрэм, журмыг батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.³

Иймд дээрх бэрхшээлийг арилгах болон Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд⁴ тусгагдсан “Хууль сахиулах байгууллагаас тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд тавих хяналтыг сайжруулах” зорилтыг⁵ хангах шаардлагад тулгуурлан Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

¹ УУХҮЯ-ны статистик мэдээллээс.

² Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. 2017 он. ХЗДХЯ

³ Мөн дээрх үнэлгээний дүгнэлт.

⁴ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоол.

⁵ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 152.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн бөгөөд хуулийн холбогдох зүйл, заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, давхардал, хийдлийг арилгах шаардлагатай талаархи дүгнэлт гарсан болно.

Иймд төслийг боловсруулахад хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон тус хуулийн хэрэгжилтэд гарч байгаа бэрхшээл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаархи хууль хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжилтнүүдийн болон иргэдийн санал, хүсэлт, бусад орны эрх зүйн зохицуулалтын сайн жишгийг харгалзан үзсэн.

Хуулийн төсөлд санал авах ажлыг иргэн, хуулийн этгээд, төрийн болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан зохион байгуулсан бөгөөд иргэдээс нээлттэй санал авахаар хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээллийн цахим хуудсанд байршуулаад байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нийт 7 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлээр тус хуульд шинээр оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг, 2, 3, 4, дүгээр зүйлээр зүйл, хэсэг, заалтад нэмэлт оруулах, өөрчлөн найруулах, өөрчлөлт оруулах зохицуулалтыг, 5, 6 дугаар зүйлээр зүйл, хэсэг, заалтаас үг, өгүүлбэр хасах, хүчингүйд тооцох, 7 дугаар зүйлээр тус хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтоох зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төсөлд дараахь нэмэлт, өөрчлөлтийг тусгасан:

1/Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг тодорхой, оновчтой болгох талаар:

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох болон өөрийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой тэсэлгээний ажил явуулах эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан агуулахтай байх, тэсрэх бодистой харьцан ажилладаг ажилчдыг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах үүргийг тодруулан хуульчлахын зэрэгцээ боловсон хүчний хувьд тавих шаардлагыг тусгай зөвшөөрлийн төрөл бүрээр нарийвчлан дүрмээр тогтоохоор зохицуулсан.
- Тэсэлгээний ажил явуулах эрхтэй хуулийн этгээдийг (бусдын захиалгаар тэсэлгээний үйлчилгээ үзүүлэх) байнгын агуулахтай байхыг шаардаж байсныг өөрчилж, харин аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тэсэлгээний ажил гүйцэтгэх газарт тухай бүр нь түр агуулах байгуулан ажиллах, тэсэлгээний ажил явуулсан тохиолдол бүрийг тогтоосон журмаар тайлагнах үүргийг хүлээлгэсэн.

2/Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага болон шинжээчийн эрх олгох, цуцлах журмыг тодорхой тогтоох талаар:

- Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрт нөлөө бүхий дүгнэлт гаргах эрхтэй “Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага”-ын болон шинжээчийн эрхийг хэн, хэрхэн олгох нь тодорхойгүй байсныг өөрчилж, холбогдох журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд батлан мөрдүүлэхээр заасан.
- Тэсэлгээчин болон перотехникийн хэрэгслийн операторчинд тавих шаардлагыг тодорхойлж, эрх олгох болон бүртгэлд хамруулах зохицуулалтыг тусгасан.

3/Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой зааглан тогтоох, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар:

- Хуулийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага ерөнхий хяналтыг хэрэгжүүлэхээс гадна тэсрэх бодисыг үйлдвэрлэх, хадгалалтын үеийн галын аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллага, ашиглалттай холбоотой хяналтыг цагдаагийн болон мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр зааглан тодорхойлсон.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс мэдээ, тайлан ирүүлэх журмыг тодорхой зохицуулж, тайлан, мэдээнд тэсрэх бодистой шууд харьцаж байгаа ажилтны тоо, хуулийн этгээдийн эрсдлийн болон ажилчдын амь нас, эрүүл мэндийн даатгал, тэсэлгээчний болон пиротехникийн операторчны бүртгэл зэргийг хамруулахаар өргөжүүлсэн.
- Тус хуулийн үйлчлэх хүрээ нь цэргийнхээс бусад зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтээр хязгаарлагдаж байгааг харгалзан тусгай зөвшөөрөл авахтай холбогдуулан Зэвсэгт хүчний жанжин штабаас санал авдаг байсныг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын санал болгон өөрчилж, аюулгүй ажиллагаа, галын болон гамшгийн эрсдэлт байдлын хяналтыг нэмэгдүүлсэн.
- Мөн тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсгээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгах, шилжүүлэх, улсын орлого болгох асуудлыг зохицуулсан нь Зөрчил шалган шийдвэрлэх болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалттай давхардсан төдийгүй гэмт хэрэг, зөрчил хянан шийдвэрлэх харилцааг энэ хуулиар зохицуулах боломжгүйг харгалзан хүчингүйд тооцсон.

4/Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах, худалдах харилцааг зохицуулах талаар:

- Пиротехникийн хэрэгслийг ашиглахтай холбоотой зохицуулалт сул байсныг өөрчилж, тодорхой зохицуулалтыг шинээр тусгалаа. Тухайлбал, пиротехникийн хэрэгслийн хүчин чадлаас хамаарч ашиглалтын болон хэрэглээний гэж ангилсан бөгөөд жагсаалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд батлахаар тусгасан. Ашиглалтын пиротехникийн хэрэгслийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хуулийн этгээд, харин хэрэглээний пиротехникийн хэрэгслийг иргэд, аж ахуйн нэгж ямар нэгэн тусгай болзолгүйгээр ашиглахаар зохицууллаа.
- Пиротехникийн хэрэгслийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйлдвэрлэх, импортлох, ашиглах бөгөөд энэ төрлийн тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээдэд олгоно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай уялдуулан боловсруулсан.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Гаалийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

-----ooOoo-----